



МОНГОЛ УЛС
БАЯНХОНГОР АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2026 оны 01 сарын 20 өдөр

Дугаар А/34

Номгон

Сумдын "Малчид төлчдийн зөвлөгөөнд оролцох, аймгийн бодлого чиглэлийг танилцуулах, санал солилцох арга хэмжээ" зохион байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.21, 66 дугаар зүйлийн 66.1, Сангийн сайдын 2021 оны 04 дүгээр сарын 20-ны өдрийн 61 дүгээр тушаалаар батлагдсан "Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам"-ын 2.1.5 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Баянхонгор аймгийн "Сумдын 2026 оны малчид төлчдийн зөвлөгөөн"-д оролцож аймгаас баримтлах дунд хугацааны бодлого чиглэлийг иргэдэд танилцуулах, цаг үеийн асуудлаар иргэдэд мэдээлэл өгөх, иргэдтэй уулзах, санал солилцох арга хэмжээг зохион байгуулсугай.

2.Сумдын малчид төлчдийн зөвлөгөөнд оролцох ажлын хэсгийг нэгдүгээр, арга хэмжээний зардалд шаардагдах зардлын тооцоог хоёрдугаар хавсралтаар баталсугай.

3.Арга хэмжээний зардалд зардалд шаардагдах 5,580,000 (Таван сая таван зуун наян мянга) төгрөгийг аймгийн Засаг даргын нөөц хөрөнгөөс зарцуулахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч (П.Отгонбаяр)-д зөвшөөрсүгэй.

4.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын орлогч (Б.Наранбаяр)-д даалгасугай.

ДАРГА



Э.ЭНХБАТ

626010379

Аймгийн Засаг даргын 2026 оны 01 дүгээр
сарын 20-ны өдрийн 01/20 дүгээр
захирамжийн 02 дугаар хавсралт



СУМДЫН МАЛЧИД ЗӨВЛӨЛИЙН ЗӨВЛӨГӨӨНД ОРОЛЦОХ,
АЙМГИЙН БОДЛОГО ЧИГЛЭЛИЙГ ТАНИЛЦУУЛАХ, САНАЛ
СОЛИЛЦОХ АРГА ХЭМЖЭЭНД ШААРДАГДАХ ЗАРДЛЫН ТООЦОО

Д/д	Арга хэмжээ	Нэгжийн үнэ	Тоо ширхэг	Нийт
1	2	3	4	5
1	Сумдын малчид төлчдийн зөвлөгөөнд шаардагдах үйл ажиллагаанд шаардагдах зардал	279,000	20 сум	5,580,000
Нийт				5,580,000

_____оОо_____

Аймгийн Засаг даргын 2026 оны 01 дүгээр
сарын 10-ны өдрийн 17.29 дүгээр
захирамжийн 01 дүгээр хавсралт



АЖЛЫН ХЭСГИЙН БҮРЭЛДЭХҮҮН

Ажлын хэсгийн ахлагч:

Б.Наранбаяр

Аймгийн Засаг даргын орлогч

Гишүүдэд:

Д.Ууганцэцэг

Аймгийн Засаг даргын зөвлөх

Э.Батцэцэг

Аймгийн Засаг даргын Тамгын газрын Төрийн
захиргааны удирдлагын хэлтсийн мэргэжилтэн

Г.Энхбаяр

Аймгийн Засаг даргын Тамгын газрын Бүс, орон нутгийн
бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтсийн дарга

Д.Дэлгэрсайхан

Аймгийн Засаг даргын хэвлэлийн төлөөлөгч

Я.Дамдинсүрэн

Аймгийн Засаг даргын Тамгын газрын Төрийн
захиргааны удирдлагын хэлтсийн хэвлэл, олон нийттэй
харилцах ажилтан

Г.Энхсайхан

Аймгийн Засаг даргын Тамгын газрын Төрийн
захиргааны удирдлагын хэлтсийн хэвлэл, олон нийттэй
харилцах ажилтан

_____оОо_____